**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/45/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг:Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: С.Батсуурь<br>Утас: 70453799, Цахим хаяг: Batsuuris@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 13
**4.1 Ерөнхий зүйл** ..... 16
**4.2 Материаллаг байдал** ..... 16
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 17
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 17
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 17
**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 17
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.08 № УВА-2023/45/НА-СТА-ТШ3
танай ______ -ны № ______ -т

УВС АЙМГИЙН ШҮҮХИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА
С.ЭНХБАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн №353 дугаар тогтоол, Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн №7109 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 2015 онд ашиглалтад орсон нийт 50,034.5 мянган төгрөгийн балансын үнэ, 10188.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг шилжүүлж үндсэн хөрөнгөнд бүртгэж авсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

0200000093

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,030,932.00** | **10,769,392.50** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **9,030,932.00** | **10,769,392.50** |
| **351** | **Түүхий эд материал** | 5,610,932.00 | 6,828,342.50 |
| **35130** | Эм боох материал | 5,610,932.00 | 6,828,342.50 |
| **354** | **Хангамжийн материал** | 3,420,000.00 | 3,941,050.00 |
| **35410** | Бичиг хэргийн материал | 170,900.00 | 244,150.00 |
| **35420** | Аж ахуйн материал | 3,249,100.00 | 3,696,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,512,303.99** | **89,017,154.07** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **27,512,303.99** | **89,017,154.07** |
| **392** | **Биет хөрөнгө** | **27,512,303.99** | **51,241,154.07** |
| **39203** | Авто-тээврийн хэрэгсэл | 31,900,000.00 | 31,900,000.00 |
| **39204** | Хуримтлагдсан элэгдэл | -15,950,000.16 | -21,266,666.88 |
| **39205** | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36,801,750.24 | 61,323,980.24 |
| **39206** | Хуримтлагдсан элэгдэл | -28,403,932.34 | -33,980,692.98 |
| **39207** | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,289,886.29 | 7,289,886.29 |
| **39208** | Хуримтлагдсан элэгдэл | -4,125,400.04 | -4,876,653.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **00.00** | **37,776,000.00** |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | **00.00** | 37,776,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **36,543,235.99** | **99,786,546.57** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **36,543,235.99** | **99,786,546.57** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **36,543,235.99** | **99,786,546.57** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **20,636,382.00** | **20,636,382.00** |
| **51101** | Өмч: - төрийн | 20,636,382.00 | 20,636,382.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **15,906,853.99** | **79,150,164.57** |
| **51210** | Өмнөх үеийн үр дүн | 15,906,853.99 | 15,906,853.99 |
| **51220** | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 63,243,310.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **36,543,235.99** | **99,786,546.57** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **243,335,600.00** | **336,624,128.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,012,500.00** | **75,127,028.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,012,500.00 | 75,127,028.70 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,012,500.00 | 5,562,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,359,000.00 | 5,562,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 7,653,500.00 | 00.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/ | | 66,765,028.70 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/ | | 2,800,000,00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **231,323,100.00** | **261,497,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 229,673,000.00 | 254,665,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 229,673,000.00 | 254,665,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,650,100.00** | **6,831,500.00** |
| ДТ(131103) | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс | | 5,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,650,100.00 | 1,831,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **244,444,794.86** | **273,380,818.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **244,444,794.86** | **273,380,818.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **244,444,794.86** | **272,012,145.05** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **182,813,800.00** | **196,422,861.56** |
| 210101 | Үндсэн цалин | 106,084,800.00 | 117,470,499.61 |
| 210102 | Нэмэгдэл | 63,585,000.00 | 62,346,123.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,144,000.00 | 12,403,138.95 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 4,203,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,707,614.02** | **4,132,276.37** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 164,999.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 19,411.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 15,529.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 3,882.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,707,614.02 | 3,928,452.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **15,209,421.00** | **15,310,389.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 758,397.00 | 988,956.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,122,240.00 | 14,122,240.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 328,784.00 | 199,193.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **18,374,850.00** | **19,575,950.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,495,500.00 | 2,572,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,125,000.00 | 13,222,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 830,000.00 | 1,375,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 198,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,726,350.00 | 2,285,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **8,714,740.00** | **9,433,089.50** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8,714,740.00 | 9,433,089.50 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **369,975.00** | **4,188,800.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 369,975.00 | 128,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 4,060,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,700,000.00** | **8,027,700.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,700,000.00 | 8,027,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,885,700.00** | **2,829,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 995,200.00 | 894,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 416,000.00 | 460,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 37,500.00 | 37,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 80,000.00 | 80,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,668,694.84** | **12,091,678.62** |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 8,668,694.84 | 12,091,678.62 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 00.00 | **1,368,673.07** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | **1,368,673.07** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,368,673.07 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-1,109,194.86** | **63,243,310.58** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-1,109,194.86** | **63,243,310.58** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**/төгрөг/**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **235,682,100.00** | **267,059,100.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,359,000.00** | **5,562,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,359,000.00 | 5,562,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,359,000.00 | 5,562,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,359,000.00 | 5,562,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **231,323,100.00** | **261,497,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **229,673,000.00** | **254,665,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 229,673,000.00 | 254,665,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,650,100.00** | **6,831,500.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,650,100.00 | 1,831,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **235,493,810.02** | **267,059,100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **235,493,810.02** | **267,059,100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **235,493,810.02** | **265,690,426.93** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 182,813,800.00 | 196,422,861.56 |
| 210101 | Үндсэн цалин | 106,084,800.00 | 117,470,499.61 |
| 210102 | Нэмэгдэл | 63,585,000.00 | 62,346,123.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,144,000.00 | 12,403,138.95 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 4,203,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,707,614.02** | **4,132,276.37** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 164,999.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 19,411.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 15,529.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 3,882.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,707,614.02 | 3,928,452.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **15,209,421.00** | **15,310,389.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 758,397.00 | 988,956.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,122,240.00 | 14,122,240.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 328,784.00 | 199,193.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **21,223,800.00** | **20,150,900.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,520,000.00 | 2,626,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,125,000.00 | 13,222,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 830,000.00 | 1,375,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,498,800.00 | 2,806,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,823,400.00** | **7,796,600.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,823,400.00 | 7,659,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 136,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,020,075.00** | **11,020,300.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,650,100.00 | 6,831,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 369,975.00 | 128,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 4,060,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,700,000.00** | **8,027,700.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,700,000.00 | 8,027,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,995,700.00** | **2,829,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,105,200.00 | 894,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 416,000.00 | 460,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 37,500.00 | 37,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 80,000.00 | 80,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **00.00** | **1,368,673.07** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 1,368,673.07 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,368,673.07 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **188,289.98** | **00.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 188,289.98 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,636,382.00** | 00.00 | 17,204,338.83 | 00.00 | **37,840,720.83** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **20,636,382.00** | **00.00** | **17,204,338.83** | **00.00** | **37,840,720.83** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -1,109,194.86 | 00.00 | -1,109,194.86 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,636,382.00** | **00.00** | **15,906,853.99** | **00.00** | **36,543,235.99** |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,636,382.00** | **00.00** | **15,906,853.99** | **00.00** | **36,543,235.99** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **20,636,382.00** | **00.00** | **15,906,853.99** | **00.00** | 36,543,235.99 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 63,243,310.58 | 00.00 | 63,243,310.58 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,636,382.00** | **00.00** | **79,150,164.57** | **00.00** | **99,786,546.57** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **258,865,600.00** | **258,858,926.93** | **6,673.07** | **100.0%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **258,865,600.00** | **258,858,926.93** | **6,673.07** | **100.0%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **258,865,600.00** | **258,858,926.93** | **6,673.07** | **100.0%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **196,424,600.00** | **196,422,861.56** | **1,738.44** | **100.0%** |
| 210101 | Үндсэн цалин | 117,470,500.00 | 117,470,499.61 | 0.39 | 100.0% |
| 210102 | Нэмэгдэл | 62,347,800.00 | 62,346,123.00 | 1,677.00 | 100.0% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,403,200.00 | 12,403,138.95 | 61.05 | 100.0% |
| 210104 | Урамшуулал | 4,203,100.00 | 4,203,100.00 | 0.00 | 100.0% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,136,400.00** | **4,132,276.37** | **4,123.63** | **99.9%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 165,100.00 | 164,999.87 | 100.13 | 99.9% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,500.00 | 19,411.97 | 88.03 | 99.5% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,600.00 | 15,529.57 | 70.43 | 99.5% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,900.00 | 3,882.40 | 17.60 | 99.5% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,932,300.00 | 3,928,452.56 | 3,847.44 | 99.9% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **15,311,200.00** | **15,310,389.00** | **811.00** | **100.0%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 989,400.00 | 988,956.00 | 444.00 | 100.0% |
| 210302 | Түлш, халаалт | 14,122,300.00 | 14,122,240.00 | 60.00 | 100.0% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 199,500.00 | 199,193.00 | 307.00 | 99.8% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **20,150,900.00** | **20,150,900.00** | | **100.0%** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,626,300.00 | 2,626,300.00 | | 100.0% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,222,800.00 | 13,222,800.00 | | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,375,600.00 | 1,375,600.00 | | 100.0% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 | | 100.0% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,806,200.00 | 2,806,200.00 | | 100.0% |
| **2105** | **Нормативт зардал** | **7,796,600.00** | **7,796,600.00** | | **100.0%** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 7,659,800.00 | 7,659,800.00 | | 100.0% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 136,800.00 | 136,800.00 | | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,188,800.00** | **4,188,800.00** | | **100.0%** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 128,800.00 | 128,800.00 | | 100.0% |
| 210604 | Урсгал засвар | 4,060,000.00 | 4,060,000.00 | | 100.0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,027,700.00** | **8,027,700.00** | | **100.0%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,027,700.00 | 8,027,700.00 | | 100.0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,829,400.00** | **2,829,400.00** | | **100.0%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 894,900.00 | 894,900.00 | | 100.0% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 | | 100.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 460,000.00 | 460,000.00 | | 100.0% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 37,500.00 | 37,500.00 | | 100.0% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 | | 100.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 | | 100.0% |
| 210807 | Газрын төлбөр | 80,000.00 | 80,000.00 | | 100.0% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **258,865,600.00** | **258,858,926.93** | **6,673.07** | **100.0%** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **254,665,600.00** | **254,658,926.93** | **6,673.07** | **100.0%** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 254,665,600.00 | 254,658,926.93 | 6,673.07 | 100.0% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **4,200,000.00** | **4,200,000.00** | | **100.0%** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,200,000.00 | 4,200,000.00 | | 100.0% |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | | 100.0% |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100.0% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **11** | **11** | | 100.0% |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | | 100.0% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **11** | **11** | | 100.0% |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 11 | 11 | | 100.0% |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөгөөр/**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,831,500.00** | **6,831,500.00** | | 100.0% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,831,500.00** | **6,831,500.00** | | 100.0% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,831,500.00 | 6,831,500.00 | | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,831,500.00 | 6,831,500.00 | | 100.0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,831,500.00 | 6,831,500.00 | | 100.0% |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,831,500.00 | 6,831,500.00 | | 100.0% |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,831,500.00 | 6,831,500.00 | | 100.0% |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | 5,000,000.00 | | 100.0% |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,831,500.00 | 1,831,500.00 | | 100.0% |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 00.00 | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шинжилгээний алба нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана. Үүнд:

1. Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулж, олон улсын стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
2. Шинжилгээний лабораториудыг магадлан итгэмжлүүлж, орчин үеийн шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжөөр хангах;
3. Шинжээч нарыг гадаад, дотоодын урт, дунд, богино хугацааны сургалтад хамруулж, мэдлэг боловсролыг дээшлүүлэн, ур чадварыг ахиулах, гадаад улс, орнуудын их, дээд сургууль болон холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах;
4. Үйлчилгээний соёлыг дээшлүүлж, иргэд, аж ахуйн нэгж, хууль хяналтын байгууллагуудад түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх.

**Эрхэм зорилго:**

Монгол Улсын хэмжээнд шүүх шинжилгээний үйл ажиллагааг төгөлдөржүүлж, дэвшилтэт техник, технологи бүхий магадлан итгэмжлэгдсэн шинжилгээний лабораториудыг ашиглан тусгай мэдлэг, мэргэжлийн түвшинд шинжилгээг хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах, мэргэшсэн алба хаагчдаар хүний нөөцийг бүрдүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

Байгууллагын үйл ажиллагаанд Шүүхийн шинжилгээний тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудыг дагаж мөрддөг.

- ✓ Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/19-ний өдрийн “Шүүхийн шинжилгээний албан хаагчийн сахилгын дүрэм”
- ✓ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/23 тушаалаар байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан.
- ✓ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог баталсан байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр, 12 сарын 23-ны өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр, 12 дүгээр сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

2022 онд тус албанд дотоод аудитын хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн салбарын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/87 дугаар тушаалаар шинэчлэн баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Шүүхийн шинжилгээний албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,243.3 мянган төгрөгөөр буюу 273 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Бараа материал | 9,030.9 | 10,769.4 | 1,738.50 |
| Үндсэн хөрөнгө | 27,512.3 | 89,017.1 | 61,504.80 |
| **Нийт хөрөнгө** | **36,543.2** | **99,786.5** | **63,243.30** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | **0.00** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 36,543.2 | 99,786.5 | 63,243.30 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **36,543.2** | **99,786.5** | **63,243.30** |

Бараа материалын дансны үлдэгдэл 10,769.4 мянган төгрөг болж 1,738.5 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд: Эм боох материал 1,217.4 мянга, бичиг хэргийн материал 73.3 мянга, аж ахуйн материал 447.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 89,017.1 мянган төгрөг болж 61,504.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь барилга байгууламж 10,851.3 мянга, машин тоног төхөөрөмж 18,945.5 мянга, бусад биет бус хөрөнгө 37,776.0 мянган төгрөгөөр тус тус өссөн, авто тээврийн хэрэгсэл 5,316.7 мянга, тавилга, аж ахуйн эд хогшлын дансны 751.2 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 254,665.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,200.0 мянга, нийт зарлагыг 258,865.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 34,613.6 мянган төгрөгөөр бууруулж, 224,052.0 мянган төгрөгөөр баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант 2022 оны 224,052.0 мянган төгрөгийн батлагдсан төсвийг 34,613.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

2022 онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 254,665.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлого 5,562.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт гүйцэтгэл 260,227.6 мянган төгрөг буюу 100 % байна.

2022 онд төсвийн зардлын хэмнэлтээс 6.7 мянга, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 1,362.0 мянга, нийт 1,368.7 мянган төгрөгийг улсад төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 254,665.6 | 254,665.6 | 0 | 100% |
| 2 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 4,200.0 | 5,562.0 | 1,362.0 | 123,8% |
| | **ДҮН** | **258,865.6** | **260,227.6** | **1,362.0** | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/367 дугаар захирамж болох орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5,000.0 мянга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 243 дугаар тушаалаар эрх олгосон үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 1,831.5 мянга, нийт 6,831.5 мянган төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлжээ.

Энэхүү нэмэлт санхүүжилтээс дижитал микроскоп авахад 5,000.0 мянга, ӨХБЗ-ийн шийдвэрээр Skyworth 55 инчийн сургалтын дэлгэц авахад 1,831.5 мянга, нийт багаж, техник, хэрэгслийн зардалд 6,831.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. /мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Засаг даргын нөөц хөрөнгө | 5,000.0 | 5,000.0 | 0 | 100% |
| 2 | Давсан орлого | 1,831.5 | 1,831.5 | 0 | 100% |
| | ДҮН | 6,831.5 | 6,831.5 | | |

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Шүүхийн шинжилгээний алба нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийллэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батсуурь гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 12/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 244.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 273.4 сая төгрөгийн 1.0 хувь буюу 2.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 2.2 сая төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Шүүхийн шинжилгээний алба нь хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 146, хугацаа хоцроож 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төсвийн зардлын эдийн засгийн ангилал мөрдөн ажиллах тухай албан шаардлагын дагуу Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” зааврыг мөрдөн ажиллаж байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шүүхийн шинжилгээний албаны хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 0 | **1** | 0 | **100** |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **0** | **1** | **0** | **100** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

| | | |
|---|---|---|
| ХЯНАСАН: | | |
| | ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | /М.БАТСУУРЬ/ |
| | АУДИТЫН МЕНЕЖЕР | /М.БАТ-АМГАЛАН/ |
| БЭЛТГЭСЭН: | АУДИТОР | /С.БАТСУУРЬ/ |

2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр